

**БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 7 дугаар
сарын 6-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ нараас 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд хуулийн төслийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулж Байнгын хорооны гишүүдийн асуултанд хариуллаа.

Хуулийн төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг аймаг, нийслэл, сум, дүүргийн сургууль, цэцэрлэгийн захирлыг томилохдоо мэдлэг, туршлага, тавигдах шаардлага хангахаас гадна хамт олны санал, хүсэлт дээр тулгуурлах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат орон нутгийн сумдын сургууль, цэцэрлэгийн захирал, багш нарыг улс төрийн албан тушаалтан буюу сумын Засаг дарга томилж, чөлөөлж байгааг өөрчлөх, хуулийн төслийг Боловсролын ерөнхий хуульд хамтатган хэлэлцэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг хуулийн төсөл нь 2020 онд шинэчлэн найруулсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай нийцэж байгаа эсэх мөн ажлын байрны тодорхойлолтыг ямар субъект баталдаг талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг хуулийн төслийг Байнгын хороонд хэлэлцэгдэж байгаа Боловсролын ерөнхий хуультай нэгтгэн нэг төсөл болгон хэлэлцүүлэгт бэлтгэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан боловсролын салбарт мэдлэггүй, сэтгэлгүй хүн томилогдож байгаа нь, мөн улс төрийн хамааралтай томилгоо хийгдэж байгаа нь орон нутагт боловсролын чанар муудаж байгаагийн шалтгаан болж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан улс, орон нутгийн сургууль, цэцэрлэгийн удирдлагууд мэргэжлийн бус байгааг анхаарч ажиллах нь зөв талаар саналуудыг тус тус хэллээ. Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ДАМДИННЯМ